

Монгол Улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагаас агаарын бохирдлын талаар гаргасан мэдэгдэл

2018 оны 12 дугаар сарын 16-ны өдөр, Улаанбаатар хот

Монгол Улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллага /НҮБ/ нь Улаанбаатар хот болон бусад суурин газруудын агаарын бохирдлын түвшин нийт хүн ам тэр дундаа хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, өндөр настан, суурь өвчтэй хүмүүсийн эрүүл мэндэд ноцтой нөлөөлж байгаад эсэргүүцлээ илэрхийлж байгаа иргэдийн хөдөлгөөнийг дэмжиж байна. Мөн энэ асуудалтай холбогдуулан цахим аянд нэгдсэн олон нийтийн санаачилгыг сайшааж байна.

Агаарын бохирдлын асуудалтай тулгараад байгаа улс орнуудын тоо нэмэгдэж байгаа бөгөөд тэдгээрийн нэг нь Монгол Улс болоод байна. Харамсалтай нь энэ асуудалд хурдан бөгөөд хялбар шийдэл байхгүй. Агаарын бохирдлын эх үүсвэр, учир шалтгааныг үстгаж, хорт утааны хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөг бууруулахад тогтвортой, урт хугацааны төрийн болоод хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт шаардлагатай.

Үүнд, цэвэр эрчим хүчний эх үүсвэрт шилжих илүү олон сонголтыг иргэдэд санал болгосноор түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлаж, улмаар хорт утааны ялгарлыг бууруулах боломжийг дэмжих хэрэгтэй байна. Цаашлаад, орон сууц, монгол гэрийн дулаалгыг чанаржуулах, агаарын чанарын хяналтыг сайжруулахын зэрэгцээ дотоод орчны агаарын чанарыг сайжруулах, агаарын бохирдол ихтэй үед гадаа гарах, гарахгүй байх цаг хугацааг олон нийтэд мэдээлж, зайлшгүй гадаа гарах шаардлагатай тохиолдолд маш сайн таарсан, зориулалтын шүүлтүүртэй амны хаалт хэрэглэж хэвшүүлэхийг зөвлөж байна.

НҮБ нь агаарын бохирдлын нөлөөг бууруулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, хэмнэлттэй, цэвэр эрчим хүчний хэрэглээг дэмжиж, урт хугацааны сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газар, нийгмийн бусад талуудад техникийн зөвлөмж, зөвлөгөө өгч, хамтран ажилласаар байх болно.

НҮБ нь бодлогын зөвлөгөө өгч, аргачлалын удирдамж гаргадаг бол хэрэгжүүлэх үйл ажиллагаа, авах арга хэмжээ болон санхүүжилтийг тухайн улсын Засгийн газар бүхий дотоодын байгууллагууд манлайлан хийх хэрэгтэйг тэмдэглэе. Монгол хүн бүр эрүүл, баталгаатай орчинд амьдрах нөхцөлийг хангахад хувийн хэвшил, иргэний нийгэм, олон нийт зэрэг олон тал бүгд оролцох нь чухал юм.

Агаарын бохирдлыг бууруулах асуудал нь бидний өмнө тулгамдаж буй нэн даруй шийдвэрлэвэл зохих асуудлуудын нэг. НҮБ нь хүн болгоны цэвэр, эрүүл агаар амьсгалах эрхийн төлөө бүхий л шийдлүүдийг эрэлхийлэхэд Засгийн газар, хувийн хэвшил болоод иргэдтэй хамтран ажилласаар байх болно.



